

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нүрэвжавын /Нүрэмжавын/ Даваа

Он сар өдөр, төрсөн газар	1913, Дундговь аймгийн Сайхан-Овоо сум
Үндсэн сүм хийд	Хутагт ламын хийд (Бари ламын хийд, Дашцэпиллин хийд, Хутагт ламын хийд буюу урд хийд, Хутагт ламын хийд буюу дунд хийд, Онгийн хутагт ламын сүм)
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Хутагт ламын хийд (Өлзийгөөр арвижуулагч хийд)
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Ойгөийн цагаан хурал



Дундговь аймгийн ,Сайхан-Овоо сум, Хутагт ламын хийд

- За та Бари ламын хийдийн тухай бидэнд ярьж өгөөч ээ. Хэдэн дугантай хэдэн ламтай байсан бэ?

...Хайдав багш, Ёнзон багш гээд олон хүмүүс байсан. Олон л хийд дуган байсан...

- Хэдэн дугантай байсан бэ?

Цогчин дуган, Шүтээн дуган, Цагаан дуган, Мамбын дуган, Жанрайсигийн дуган, Чойрын дуган, Цогчин дуган гэж хэлсэн билүү....

- Тийм. Гэвшийн дамжаа байсан уу?

Барьж байсан болов уу даа. Гавжийн дамжаа байсан.

- Чойрын дацан ямар игчатай байсан бэ?

Гүнчэн ламын игча.

- Хэдэн суваргатай байсан бэ? Том хүрд, суварга байсан уу?

Их олон байсан. Цагаан суварга гээд олон суварга байсан. Дүйчэн өдрөөр гэрэл гардаг байсан гэдэг.

- Суварганаас уу?

Тийм.

- Аль овоогоо тахидаг байсан бэ?

Шашир гээд овоог тахидаг байсан. Хавар. Лам нар барилдаад багачуул уралдаад байдаг байсан байсан. Зуны эхэн сарын шинийн 3-д Сайхан овоогоо тахиж, тэгээд Баян-Өндөр. Тэгээд Мандал овоо.

- Тэнд зоч лам байсан уу?

Аан, зоч Манчир зоч гээд их сүрхий лам байсан. Их мэдлэг лам гэж байсан. Аг тарнийн идтэй хүн байсан.

- Зочийн дуган гэж тусдаа дуган байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүр дсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр нэг юм бариад л орчихдох байсан байх аа... Ванчин ламбугай байшинд л хонх дамараа тавиад жигтэй хурал хураад, лүйжин тавина, олон хүн цугладаг байсан. Ванчин лам сүрхий ч хүн байсан ч байхаа.

- Энэ хийд анх байгуулагдсан тухай түүхийг мэдэх үү? Хэдэн онд хэний санаачлагаар байгуулагдсан бэ?

Энэ хийдийг л лав Дээд Ханчин лам эсвэл Бари лам, Их найдан багш.

- Та хэдэн хүртэл тэнд суусан бэ?

Найман настайгаасаа арваад жил суусан байх.

- Хийдийн гол сахиус?

Гомбо лам

- Хайлан хурдаг бийсан уу?

Байлгүй яахав.

- Лам нарыг хэдэн онд барьсан бэ?

27-28 жил... Би тэгж сайн мэдэхгүй.

- Хэдэн онд дуганыг буулгасан бэ?

Мэдэхгүй. Ерөөсөө...

- Сумын төвөөс баруун хойно Ойгчийн цагаан хурал гээд байдаг шүү дээ. Та сонсож байв уу?

Ойгчийн цагаан суварга

- Тийм суваргатай доогуур нь тэмээ гардаг байсан. Мөн үү? Тэнд нэг 3 сүм дугана байсан юм шиг байна.

Тиймээ. Цөөхөн дугантай байсан байх шүү. Ёнзон багш гэж тэнд очиж байсан байх аа.

- Мянган бурханыг хэн бүтээсэн гэнээ ?

Халзан гэвш.

- Тэр Ойгчийн цагаан суварганы тухай яриач?

Ойгчийн ёнзон багшийн л хамбын ёнзон багш юм байгаа юм... Цөөхөн ламтай байсан.

- Ёнзон багш нь төвд хүн байсан уу?

Монгол хүн.

- Бари ламын хийдийн төвд нэр нь юу байсан бэ?

Гүндүйжамбалин.

- Та Бари ламын хийдийг сэргээсэн тухай ярьвал? Хэдэн онд сэргээв?

Батгэрэл (Бат-Идэр?) гэдэг лам толгойлж удирдаад сэргээсэн

- Хуучин хийдээс авч үлдсэн сахиус байгаа юу?

Мэдэх юм алга байна шүү.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр